

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын
2018 оны санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: САГ-2019/111/СТА-ТӨҮГ

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
	2.1. Оршил.....	4
	2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
	2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
	2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
	2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
	2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
	2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
	2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
	2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
	2.10. Үйл ажиллагааны орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга.....	7
	2.11. Шилэн дансны мэдээлэл	7
	2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
	2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	9
	3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	9
	3.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	10
	3.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	11
	3.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
	3.5 Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулгын тайлан.....	13

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.20 № 06/534
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус төвийн гүйцэтгэх захирал Д.Энхтөмөр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, тодруулгад аудит хийлээ.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт гаргах нь энэхүү аудитын зорилт байв.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 3 дугаар сарын 5-наас 3 дугаар сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Эвиденсе Аудит ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ нь 2018 оны санхүүгийн тайлан, тодруулгын хамт 2019 оны 3 дугаар сарын 13-ны 49 тоот албан бичгээр Эвиденсе Аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, СТОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Монгол Улсын Засгийн газар болон Кувейт улсын Засгийн газар хооронд "хүрээлэн буй орчныг хамгаалах салбарт хамтран ажиллах тухай" харилцан ойлголцлын санамж бичгийг 2007 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хоёр тал үзэглэж "Монгол-Кувейтын судалгааны төв" байгуулагдсан.

Засгийн газрын 2016 оны 110 дугаар тогтоолоор "Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв"-ийг аж ахуйн тооцоотой улсын үйлдвэрийн газар болгон Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяанд ажиллуулахаар шийдвэрлэсэн.

Чиг үүрэг: Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр судалгаа, шинжилгээ хийх, эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, мэдээлэл, сургалт, сурталчлагааны ажил зохион байгуулах.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын удирдлага дараах хууль болон түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Компанийн тухай хууль
- Байгаль орчны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Ноён” програм хангамж ашигладаг байна.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөтэй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 3 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 3 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын үзүүлэлтийг сонгов.

Санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь уг компани нь төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, мөн бусад үзүүлэлтүүдээс хамгийн бага дүнтэй тул сонгосон ба материаллаг байдлын түвшинг тогтоохдоо хэрэглэгчдийн хэрэгцээ, өмнөх жилийн аудитын тайлангаар гарсан алдаа, зөрчлийн дүн, агуулгыг бас харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн Нийт орлого 486.9 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 4.9 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь тухайн байгууллага аудитын чиглэлүүдэд үзүүлж болзошгүй эрсдлийг харгалзан үзсэнтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 3 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй болно.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

2.10. Үйл ажиллагааны орлого, зардал, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга

Тус байгууллага нь 2018 оны зорилтот түвшинд нийт орлогыг 700.0 сая төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр амралт зугаалгаас олох орлогоос 486.9 сая төгрөгийн орлого олж орлогын төлөвлөгөөг 69.6 хувь буюу 213.0 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна.

Нийт зардалд 683.6 сая төгрөг, үүнээс борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 651.8 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 31.8 сая төгрөг зарцуулахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 743.7 сая төгрөг, ерөнхий ба удирдлагын зардалд 34.9 сая төгрөг нийт зардалд 778.6 сая төгрөгийг зарцуулсан ба 291.6 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгнөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн нэгтгэсэн мэдээллийг, зорилтот түвшний гүйцэтгэлийг, хөрөнгө оруулалт, худалдан авалт, хагас жилийн санхүүгийн тайланг тус тус байршуулсан байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Аудит хийсэн санхүүгийн тайлан**3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017 оны 12-р сарын 31	2018 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,299,119.10	9,095,078.64
1.1.2	Дансны авлага	59,875,337.12	10,381,590.12
1.1.4	Бусад авлага	3,443,828.14	477,688.08
1.1.6	Бараа материал	110,524,204.14	123,979,821.47
	Эргэлтийн хөрөнгийн дүн	183,142,488.50	143,934,178.31
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	7,706,537,473.22	7,478,609,704.01
1.2.2	Биет бус хөрөнгө	1,633,500.00	1,435,500.00
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	7,708,170,973.22	7,480,045,204.01
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,891,313,461.51	7,623,979,382.33
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	14,744,100.00	23,944,344.85
2.1.1.2	Цалингийн өглөг	238,356.50	2,576,174.71
2.1.1.3	Татварын өр	5,406,686.44	13,976,263.33
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	28,800.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,960,000.00	6,076,500.00
2.1.1.3	Богино хугацаат өр төлбөрийн дүн	22,349,142.94	46,602,082.89
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	22,349,142.94	46,602,082.89
2.3	Эздийн өмч		
2.3.1	Төрийн	8,057,023,860.11	8,057,023,860.11
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-188,059,541.54	-479,646,560.67
2.3.11	Эздийн өмчийн дүн	7,868,964,318.57	7,577,377,299.44
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	7,891,313,461.51	7,623,979,382.33

3.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого(Цэвэр орлого)	341,055,650.00	356,214,508.65
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	92,713,561.55	65,649,477.93
3	Нийт ашиг (алдагдал)	248,342,088.45	290,565,030.72
5	Хүүний орлого	86,547.43	175,429.96
8	Бусад орлого	352,800.00	130,574,848.18
10	Ерөнхий ба удирдлагын зардал	169,033,504.26	704,459,864.77
12	Бусад зардал	300,000.00	8,450,000.00
14	Гадаад валютын ханшийн зөрүүний олз гарз	30,455.42	7,536.77
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	79,478,387.04	-291,587,019.14
19	Орлогын татварын зардал	8,654.74	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	79,469,732.30	-291,587,019.14
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	79,469,732.30	-291,587,019.14
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.3	Бусад олз/гарз		
24	Орлогын нийт дүн		

3.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2017 оны 1 сарын 1-ний үлдэгдэл	8,057,023,860.11	-	-188,059,541.54	7,868,964,318.57
9	2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	8,057,023,860.11		-188,059,541.54	7,868,964,318.57
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-	-
11	Залруулсан үлдэгдэл	8,057,023,860.11		-188,059,541.54	7,868,964,318.57
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			-291,587,019.13	-291,587,019.13
13	Өмчид гарсан өөрчлөлт	-	-		-
15	Зарласан ногдол ашиг			-	-
16	Дахин үнэлгээний нэмэгдэл			-	-
17	2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	8,057,023,860.11	-	-479,646,560.67	7,577,377,299.44

3.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	334,822,246.11	355,196,846.52
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	334,698,750.00	352,030,287.96
1.1.4	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	43,386.00	333,501.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	80,110.11	2,833,057.56
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	334,513,474.05	345,820,653.71
1.2.1	Ажилчдад төлсөн мөнгө	104,797,128.92	108,401,336.63
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	32,528,831.01	31,948,543.37
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	38,787,884.57	38,091,284.49
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	71,050,367.05	38,707,103.49
1.2.5	Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,996,635.00	3,271,280.00
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	9,375,300.00	3,124,043.19
1.2.7	Даатгалын төлбөрт төлсөн	89,100.00	196,010.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	64,888,227.50	122,081,052.54
1.3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	308,772.06	9,376,192.81
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	60,437.32	55,429.96
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	60,437.32	55,429.96
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,396,880.00	9,643,200.00
2.2.5	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	4,396,880.00	9,643,200.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны дүн	-4,336,442.68	-9,587,770.04
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,130,455.42	7,536.77
3.1.1	Зээл авсан өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	10,100,000.00	-
3.1.4	Бусад орлого	30,455.42	7,536.77
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	10,100,000.00	-
3.2.1	Зээл өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	10,100,000.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	30,455.42	7,536.77
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-3,997,215.20	-204,040.46
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,296,334.30	9,299,119.10
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,299,119.10	9,095,078.64

3.5 Аудит хийсэн зорилтот түвшин, гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулгын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан /мянган төгрөгөөр/

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	2018		Хувь	Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Рестораны орлого				
Үүнээс	Экологийн боловсрол олгох сургалтаас олох орлого				
	Амралт зугаалгаас олох орлого	700,000.00	486,964.70	69.6	-213,035
	Хурал семинар зохион байгуулсанаас орох орлого				-
	Нийт орлого	700,000.00	486,972.20	69.6	-213,028
2	Нийт зардал	683,618.20	778,559.30	113.9	94,941
3	Үүнээс: Удирдлагын зардал	31,821.44	34,865.50	109.6	3,044
	Татварын өмнөх ашиг	16,381.80	-291,587.00	-1,779.9	-307,969
4	Цэвэр ашиг/алдагдал	14,743.62	-291,587.00	-1,977.7	-306,331
5	а. Орлогын татварт	1,638.18		-	-1,638
6	в. НДШ	15,375.40	15,586.40	101.4	211
	г. НӨАТ		8,936.20		8,936
	д. Үл хөдлөх хөрөнгийн татварт	44,125.20		-	-44,125
	ж. Тээврийн хэрэгслийн татвар	584.5	252.7	43.2	-332
	Төрийн өмчийн ноогдол ашигт				-
7	Нийт ажиллагсадын тоо	13	13	100.0	-
8	Нийт цалингийн сан	139,776.00	129,194.70	92.4	-10,581
9	Нэг ажилчины дундаж цалин	896	828.17	92.4	-68
10	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	0.98	1.71	174.5	1
11	Хөрөнгө оруулалт/өөрийн хөрөнгөөр /	41,500.00	34,743.20	83.7	-6,757
12	Нийт авлага	-	6,375.10		
13	Нийт өглөг:	-	25,200.00		

